



## ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан  
бүртгэх орон тооны бус байнгын комиссын  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Дүрэм шинэчлэн батлах тухай 269 дүгээр тогтоол, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5.5, 9.5.8 заалтыг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Компанийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд шалтгааныг тогтоох, судлан бүртгэх, акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий Орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтэн
	Захиргаа, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн
	Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч
	Аж ахуй, кемп, үйлчилгээний хэлтсийн дарга
	Хэлтсийн дарга /Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан хэлтсийн/
	Ерөнхий эмч

2. Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу

0220761

компанид гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл, цаашид хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сэрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, тухайн хэлтэст холбогдох шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллахыг Орон тооны бус байнгын комисст үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/56 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх Орон тооны бус байнгын комиссын дарга /Д.Хишигдорж/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.УДААНЖАРГАЛ